



МАНДАЛ
ДААТГАЛ

15
ЖИЛ

**ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРАЛ
2026**

2026.03.28 | 12:00 цаг

АГУУЛГА

1. Хурлын зар
2. Хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох бичиг баримтын жагсаалт, уг бичиг баримттай танилцаж болох газар, хугацаа
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах комиссын бүрэлдэхүүн
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зарлан хуралдуулах тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын тогтоол
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын бүрэлдэхүүн
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэг
7. Компанийн 2025 оны бизнесийн үйл ажиллагааны тайлан танилцуулах
8. Компанийн 2025 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах
9. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах
10. Компанийн ногдол ашиг тараах эсэх талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан шийдвэр танилцуулах
11. ТУЗ-ийн ердийн 2 гишүүнийг томилох
12. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны үйл ажиллагааны зардлын төсөв батлуулах
13. Тогтоолын төсөл
14. Саналын хуудас
15. Итгэмжлэлийн загвар

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ЗАР

“Мандал Даатгал” ХК (цаашид “Компани” гэх)-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (цаашид “Ээлжит хурал” гэх)-ыг 2026 оны 03 сарын 28-ны өдрийн 12 цаг 00 минутаас “Мандал Даатгал” ХК-ийн албан ёсны фэйсбүүк www.facebook.com/mandaldaatgal хаягаар дамжуулан цахимаар хуралдах тул та бүхэн хуралдаа идэвхтэй оролцоорой.

Хувьцаа эзэмшигчдийн ирц, санал хураалт, асуултыг www.investmentexpo.mn сайтаар хүлээн авна.

Ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэн, шийдвэрлэнэ. Үүнд:

1. Компанийн 2025 оны бизнесийн үйл ажиллагааны тайлан танилцуулах;
2. Компанийн 2025 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлт танилцуулах;
3. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;
4. Компанийн ногдол ашиг тараах эсэх талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан шийдвэр танилцуулах;
5. ТУЗ-ийн ердийн 2 гишүүнийг томилох;
6. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны үйл ажиллагааны зардлын төсөв батлах;

Ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр нь 2026 оны 03 сарын 02-ны өдөр (цаашид “Бүртгэлийн өдөр” гэх) байна.

Бүртгэлийн өдрөөр тасалбар болгосон Хувьцаа эзэмшигчийн нэрсийн жагсаалтад орсон хувьцаа эзэмшигч нь Ээлжит хуралд өөрөө эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан оролцох эрхтэй ба Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө – 24, Паркплэйс оффис, 3 давхар хаягаар болон Тооллогын комиссоор дамжуулан Ээлжит хурлаар хэлэлцэх асуудалд өгөх саналаа саналын хуудсаар урьдчилан өгөх боломжтой.

Хэрэв хувьцаа эзэмшигч нь хуулийн этгээд бол хуулийн этгээдийг төлөөлөн хуралд оролцогч нь хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар, Гүйцэтгэх захирал биш бол хуулийн этгээдээс олгосон хүчин төгөлдөр итгэмжлэлийг заавал авчрах шаардлагатай. Саналын хуудсаар санал авах сүүлийн хугацаа 2026 оны 03 сарын 28-ны өдрийн 12 цаг 00 минут хүртэл байна.

Ээлжит хурлын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Компанийн байранд болон хурал зохион байгуулах комиссын дараах хаягаар холбогдон авна уу.

№	Комиссын гишүүн	Утасны дугаар	Шуудангийн хаяг
1	Б.Энхтүвшин	9903-4515	enkhtuvshin@mandal.mn

Ажиллах цагийн хуваарь: Ажлын өдрүүдэд 9⁰⁰–17⁰⁰ цагийн хооронд ажиллана.

Компанийн хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө 24, Сөүл рестораны баруун талд Паркплэйс Оффис, 3 давхарт.

Имэйл: enkhtuvshin@mandal.mn

Утас: 7575-2000

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛТАЙ ХОЛБООТОЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАНИЛЦВАЛ ЗОХИХ МЭДЭЭЛЭЛ, БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчид нь 2026 оны 02 сарын 14-ний өдрөөс эхлэн 2026 оны 03 сарын 28-ны өдрийг хүртэл ажлын өдрүүдийн 09:00 – 17:00 цагийн хооронд “Мандал Даатгал” ХК-ийн оффист болон өөрийн харилцаж буй брокер, дилерийн компаниуд дээр очиж дараах баримт бичгүүдтэй танилцах боломжтой. Үүнд:

1. Хурлын зар;
2. Хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох бичиг баримтын жагсаалт, уг бичиг баримттай танилцаж болох газар, хугацаа;
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах комиссын бүрэлдэхүүн;
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зарлан хуралдуулах тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын тогтоол;
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын бүрэлдэхүүн;
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэг;
7. Компанийн 2025 оны бизнесийн үйл ажиллагааны тайлан;
8. Компанийн 2025 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлт;
9. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлт;
10. Компанийн ногдол ашиг тараах эсэх талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан шийдвэр;
11. ТУЗ-ийн ердийн 2 гишүүнийг томилох;
12. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны үйл ажиллагааны зардлын төсөв;
13. Тогтоолын төсөл;
14. Саналын хуудас;
15. Итгэмжлэлийн загвар.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Зохион байгуулах комиссын дарга: *Б.Энхтүвшин /ТУЗ-ийн нарийн бичгийн дарга/*

Зохион байгуулах комиссын гишүүд: *Н.Хүслэн /Маркетингийн ахлах менежер/
Т.Анхзаяа /Контент хариуцсан ахлах менежер/*

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ



МАНДАЛ
ДААТГАЛ

2026 оны 02 сарын 10 өдөр
Дугаар 26/006
Улаанбаатар хот

МАНДАЛ ДААТГАЛ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг
зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4 дэх хэсэг, 60 дугаар зүйл, 71 дүгээр зүйлийн 71.3 дэх хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.2 дэх хэсэг, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 12 сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам" болон, "Мандал Даатгал" ХК (цаашид "Компани" гэх)-ийн Дүрэм (цаашид "Дүрэм" гэх)-ийн 8-р зүйлийн 8.13.3 болон 8.13.4 дэх хэсгийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2026 оны 03 сарын 28-ны өдрийн 12 цаг 00 минутаас "Мандал Даатгал" ХК-ийн албан ёсны фэйсбүүк www.facebook.com/mandaldaatgal хаягаар дамжуулан цахимаар хуралдуулсугай.
- Хувьцаа эзэмшигчдийн ирц, санал хураалт, асуултыг www.investmentexpo.mn вэбсайтаар хэрэгжүүлсүгэй.
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцүүлсүгэй. Үүнд:
 - Компанийн 2025 оны бизнесийн үйл ажиллагааны тайлан танилцуулах;
 - Компанийн 2025 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах;
 - Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;
 - Компанийн ногдол ашиг тараах эсэх талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан шийдвэр танилцуулах;
 - ТУЗ-ийн ердийн 2 гишүүнийг томилох;
 - Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны үйл ажиллагааны зардлын төсөв батлах;
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2026 оны 03 сарын 02-ны өдрөөр тасалбар болгон Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөр хийлгэсүгэй.
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг энэхүү тогтоолын **Хавсралт №1**-ээр баталсугай. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг 2026 оны 02 сарын 16-ны өдөр болон 2026 оны 02 сарын 27-ны өдрүүдэд өдөр тутмын сонинд, Компанийн www.mandal.mn вэбсайт болон Монголын хөрөнгийн биржийн www.mse.mn цахим хуудсаар 2026 оны 02 сарын 14-ний өдрийн дотор хувьцаа эзэмшигчдэд мэдээлсүгэй.
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой Хувьцаа эзэмшигчдийн танилцвал зохих мэдээлэл, баримт бичгийн жагсаалтыг **Хавсралт №2**-оор баталсугай.

МАНДАЛ ДААТГАЛ ХК | Регистрийн дугаар: 5473489
Хаяг: Паркплэйс Оффис, Чингисийн өргөн чөлөө-24, Сүхбаатар дүүрэг,
1-р хороо, Улаанбаатар хот 14241, Монгол улс
Шуудангийн хаяг: Ш/х-2772/2292 Улаанбаатар 15160

☎ (976) 7575 2000
@ info@mandal.mn
🌐 www.mandal.mn

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ



МАНДАЛ
ДААТГАЛ

2026 оны 02 сарын 10 өдөр

Дугаар 26/006

Улаанбаатар хот

- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэн шийдвэрлэх асуудлаар өгөх саналыг саналын хуудсаар авах бөгөөд саналын хуудасны агуулга болон загварыг **Хавсралт №3**-аар баталсугай. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд биечлэн оролцоогүй боловч саналын хуудсаар дамжуулан урьдчилан саналаа ирүүлсэн хувьцаа эзэмшигчийг хуралд оролцсон гэж үзэх бөгөөд уг саналын хуудсыг хүлээн авах сүүлийн хугацаа нь 2026 оны 03 сарын 28-ны өдрийн 12 цаг 00 минут хүртэл байна.
- Энэхүү тогтоол батлагдан гарсантай холбогдуулан 2026 оны 02 сарын 12-ны өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл, энэхүү тогтоолын Хавсралт №1 болон Хавсралт №2 дахь мэдээлэл болон Компанийн тухай хуулийн 80.11-т заасан мэдээллийн хамт хүргүүлсүгэй.
- Энэхүү тогтоол батлагдан гарсантай холбогдуулан Хавсралт №2-оор баталсан мэдээлэл, баримт бичгийн төслийг хэвлэмэл болон цахим хэлбэрээр 2026 оны 02 сарын 14-ний өдөр хувьцаа эзэмшигчдэд үйлчилж буй брокер, дилерийн компаниудад хүргүүлсүгэй.
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга Өлзийбаяр овогтой Ганзоригийг томилсугай.
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар батлах тогтоолын төслийг **Хавсралт №4**-еер баталсугай.
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнийг **Хавсралт №5**-аар баталсугай.
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох төлөөлөгчийн итгэмжлэлийн загварыг **Хавсралт №6**-аар баталсугай.
- Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох мэдээлэл, баримт бичгийг хүргүүлэх, бүртгүүлэх ажлыг хийж гүйцэтгэхийг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн дарга Балдан овогтой Энхтүвшинд даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ө. ГАНЗОРИГ

МАНДАЛ ДААТГАЛ ХК | Регистрийн дугаар: 5473489
Хаяг: Парклайс Оффис, Чингисийн өргөн чөлөө-24, Сүхбаатар дүүрэг,
1-р хороо, Улаанбаатар хот 14241, Монгол улс
Шуудангийн хаяг: Ш/х-2772/2292 Улаанбаатар 15160

☎ (976) 7575 2000
@ info@mandal.mn
🌐 www.mandal.mn

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ

Хугацаа	Хөтөлбөр	Хариуцагч
12:00 - 12:05	Хурлын ирц бүртгэх	Тооллогын комисс
12:05 - 12:10	Хурлын ирцийг мэдээлэх	Тооллогын комисс
12:10 - 12:15	Хурлын дэгийг танилцуулна	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга
12:15 - 12:20	Хурлын дарга хурлыг нээж үг хэлнэ	Хурлын дарга – Ө.Ганзориг
12:20 - 12:30	Компанийн 2025 оны бизнесийн үйл ажиллагааны тайлан	Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Б.Энхтүвшин
12:30 - 12:40	Компанийн 2025 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах	Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Б.Энхтүвшин
12:40 - 12:50	Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах	Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Б.Энхтүвшин
12:50 - 12:55	Компанийн ногдол ашиг тараах эсэх талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан шийдвэр	Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Б.Энхтүвшин
12:55 - 13:05	ТУЗ-ийн ердийн гишүүдийг сонгон шалгаруулах	Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Б.Энхтүвшин
13:05 - 13:10	Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны үйл ажиллагааны зардлын төсөв батлуулах	Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Б.Энхтүвшин
13:10 - 13:20	Асуулт хариулт	Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Б.Энхтүвшин
13:20 - 13:35	Санал хураалт	Б.Энхтүвшин
13:35 - 13:45	Хурлын завсарлага, санал тоолох	Тооллогын комисс
13:45 - 13:50	Санал хураалтын дүнг танилцуулах	Тооллогын комисс
13:50 - 13:55	Хурлаас гарах тогтоолын төслийг танилцуулах	Тооллогын комисс
13:55 - 14:00	Хурлын дарга хурлыг хааж үг хэлнэ	Хурлын дарга – Ө.Ганзориг

МАНДАЛ ДААТГАЛ ХК-ИЙН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

“Мандал Даатгал” ХК нь 2025 онд компанийн урт хугацааны тогтвортой хөгжлийг дэмжсэн, эрсдэлийг бодитоор бууруулахад чиглэсэн, бизнесийн орчин, менежментийн чадавхыг дээшлүүлэх зорилго бүхий арга хэмжээнүүдийг амжилттай зохион байгуулж, компанийн нийгэмд үзүүлэх үнэ цэнийг нэмэгдүүлэхэд чиглэж ажиллалаа.

2025 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

“50 ХҮНИЙ АМЬ АВРАХ” ТӨСӨЛ

“АЛТЕПЛАЗА”

Алтеплаза нь хурц шигдээс, харвалтын үед анхны шинж тэмдэг илэрснээс хойш алтан цаг буюу 2-4 цагийн дотор хийгдэх өндөр түвшний эмчилгээ юм. Ингэснээр тухайн харвалтаас үүдэж бий болох хөдөлмөрийн чадвар алдалт, саажилт, амь насаа алдах эрсдэл багасна. Хэдий хүний амь насыг богино хугацаанд аврах шидтэй ч гэлээ, нэгж алтеплаза тунгийн үнэ өртөг нь өндөр учраас улсын хэмжээнд хүртээмж, нөөц хангалтгүй байдаг. Иймд “Мандал Даатгал” ХК-иас нэн яаралтай үед хүний амь аврах энэхүү эмийн хүртээмжийг нэмэгдүүлэх ажлыг хэрэгжүүлж эхэлсэн билээ.

Үзүүлэлт	Тоо хэмжээ
Ашиглагдсан тун	75
Амь аврагдсан хүний тоо	38
Эмчилгээний үр дүн	100%
Үр дүн	Нас баралт, хөдөлмөрийн чадвар алдалтын эрсдэлийг таслан зогсоосон Иргэдэд ирэх эрүүл мэндийн зардлын ачааллыг 100 гаруй сая төгрөгөөр бууруулсан Монголын тэргүүлэх зэргийн эмнэлэгтэй стратегийн түншлэлийг бий болгосон

“ҮЕР, УСНЫ ОСЛЫН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ” ТӨСӨЛ

“ГОЛЫН ЭРГИЙН КАМЕР”

Улаанбаатар хот нь Туул голыг дагасан үер, усны эрсдэлтэй бүсэд оршдог. Үүнийг дагаад дулааны улиралд усны ослын улмаас амь насаа алдах иргэдийн тоо эрс нэмэгддэг билээ.

“Мандал Даатгал” ХК нь “Нийслэлийн Онцгой Байдлын Ерөнхий Газар”-тай хамтран үер, усны ослыг бууруулах зорилгоор Туул голыг дагасан үер, усны ослын хамгийн өндөр эрсдэлтэй цэгүүдэд аюулыг мэдээлэх 5 цамхгийг байгуулж, тогтвортой үйл ажиллагааг ханган ажилласаар байна. Уг цамхаг нь үер, усны ослын эрсдэлтэй тохиолдлыг 200 метрийн радиуст татаж харах чадалтай хяналтын камертай ба дуут дохио ашиглан иргэдэд сэрэмжлүүлэг мэдээллийг хүргэдэг.

Үзүүлэлт	Тоо хэмжээ
Цамхгийн тоо	5
Хяналтын радиус	200 метр
Камер+дуут дохиотой бүс	Туул голын эрсдэл өндөртэй цэгүүд
Ослын тохиолдол буурсан байдал	3.5 дахин
Цамхгийн бүсэд тохиолдсон осол	0
Үр дүн	Үер, усны ослыг бууруулсан Нийслэлийн иргэлдийн аюулгүй байдлыг хангасан “Онцгой Байдлын Ерөнхий Газар”-тай итгэлцлийн түншлэлийг бий болгосон

“БАГА НАСНЫ ХҮҮХДҮҮДЭД ЭРСДЭЛИЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ” ТӨСӨЛ

“МАНДАЛ ЭРСДЭЛИЙН СУРГУУЛЬ”

Жил бүр 40,000 гаруй хүүхэд урьдчилан сэргийлэх боломжтой шалтгааны улмаас эрүүл мэнд, амь насаараа хохирдог гэсэн харамсалтай үзүүлэлт бий. Дөрөв дэх жилдээ хэрэгжүүлж буй уг төслийн хүрээнд 2-12 насны хүүхдүүдэд тэдний хөгжлийн онцлогт суурилан түгээмэл тохиолдох эрсдэлүүдийн талаарх 3 бүлэг 20 видео онлайн хичээлийг үнэ төлбөргүй бэлтгэн хүргэж, Нийслэлийн 400 гаруй цэцэрлэгийн сургагч багш нарт сургалтын мэдээллийг хүргэж ажилласан байна.

Үзүүлэлт	Тоо хэмжээ
Видео хичээл	20
Хамрагдсан хүүхдийн тоо	35,000 гаруй
Сургагч багш нарт мэдээлэл хүргэсэн	400 гаруй цэцэрлэгийн сургагч багш нар
Хичээл бататгах тэмцээн уралдаан	Нийт хүүхэд багачуудыг хамарсан 5 удаагийн хичээл бататгах тэмцээн уралдааныг зохион байгуулсан

МОНГОЛЫН АНХНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН НЭГДСЭН ПЛАТФОРМ

“eDoctor”

Үзүүлэлт	Тоо хэмжээ
Тогтмол уншигч	1.5 сая
Өвчний дэлгэрэнгүй мэдээлэл	250+
Зөвлөмж нийтлэл	100+
Подкаст	35 гаруй нарийн мэргэжлийн эмч нартай хамтран өвчлөлийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл олгох подкастыг бэлтгэн нийтэлсэн
Үр дүн	Иргэдийг эрүүл мэндийн баталгаатай эх сурвалжаар хангаж ажиллаж байна Эрүүл мэндийн суурь боловсролыг нэмэгдүүлсэн

АЖЛЫН БАЙРТАЙ, ТЭТГЭЛЭГТЭЙ ЭЛСЭЛТ

“Мандал Санхүүгийн Нэгдэл”-ийн охин компаниуд нь “Санхүү эдийн засгийн их сургууль”-тай хамтран “Санхүү&Банк”-ны бакалаврын зэрэг олгох хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн. Уг хөтөлбөрийн хүрээнд нийт 28 оюутныг ажлын байраар хангахын зэрэгцээ, их сургуулийн сургалтын төлбөрийг шийдвэрлэлээ. Ингэснээр 3 жилийн хугацаанд бакалаврын зэрэг эзэмших бөгөөд онолын ба практик мэдлэгийг эзэмшиж, топ мэргэжилтэн болж төлөвших боломжийг бүрдүүлж байгаа юм.

БИЗНЕСИЙН ОРЧИН, МЕНЕЖМЕНТИЙН ЧАДАВХЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

“Мандал Даатгал” ХК нь жил бүр нийгэм, эдийн засагт тулгарч буй эрсдэлүүдийг шийдэх арга замыг эрэлхийлж, менежментийн арга туршлагуудаа хуваалцах зорилгоор Монголын ТОП бизнес эрхлэгчдэд зориулан “Next Leaders”, “Management Forum”, “Эрсдэлийн форум” зэрэг арга хэмжээг зохион байгуулдаг. Тус арга хэмжээнүүд нь бизнес эрхлэгчдэд хамтын ажиллагаагаа хөгжүүлэх, бизнесийн хүрээлэл болон борлуулалтаа тэлэх боломжийг олгодог гэдгээрээ онцлог.


Монгол улсыг иргэдийнхээ өмнө сайн дураар өөрийнхөө бизнесийн үйл ажиллагаанаас давсан хариуцлага хүлээж чаддаг, хүнлэг том амбицтай компаниуд нэгдэн хөгжүүлж чадна гэдэгт бид итгэлтэй байдаг.

1. ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА


2025 оны 4-р улирлын байдлаар Цэвэр хураамжийн орлого 54.6 тэрбум төгрөг буюу 30.7%-иар өсөж, 2025 оны 3-р улирлын байдлаар нийт зах зээлийн 15.9%-ийг эзэлж байгаа бөгөөд компанийн борлуулалтын төлөвлөгөө 106%-ийн биелэлттэй байна.

Цэвэр хураамжийн орлого сүүлийн 5 жилийн дунджаар 30.8%-иар өссөн байна.

Нийт хураамжийн орлого, тэрбум төгрөг




Цэвэр хураамжийн орлого, тэрбум төгрөг



Цэвэр хураамжийн орлогын 49.4%-ийг Эрүүл мэндийн даатгал эзэлж байгаа нь өмнөх оноос 86%-иар өсөж, 26.9 тэрбумтөгрөгт хүрсэн байна.

Хураамжийн орлогын бүтэц, бүтээгдэхүүнээр




Эрүүл мэнд	49.4%
Машины даатгал	25.7%
Хөрөнгө	11.8%
Гэнэтийн осол	8.4%
Хүнд даацын ТХД	2%
Бусад	3.1%


2025 онд 18,460 харилцагчдад 27.4 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгосон нь өмнөх оноос 58%-иар өссөн бөгөөд 2025 оны 3-р улирлын байдлаар нийт зах зээлийн 14%-ийг эзэлснээр салбартаа нөхөн төлбөр олголтоор 2 дугаарт байна. Мөн нийт нөхөн төлбөрийн тохиолдлын 94.2%-ийг шийдвэрлэсэн бөгөөд хохирлын харьцаа 53.8% болсон нь өмнөх оноос 1.7%-иар өссөн үзүүлэлттэй байна.

Нийт нөхөн төлбөрийн 69%-ийг Эрүүл мэндийн даатгалд олгосон байна.


Нөхөн төлбөр авсан даатгуулагчийн тоо



Нийт нөхөн төлбөрийн дүн, тэрбум төгрөг



Олгосон нөхөн төлбөр, бүтээгдэхүүнээр



Эрүүл мэндийн даатгал	69%
Машины даатгал	20%
Хөрөнгө	3%
Гэнэтийн осол	3%
Бусад	5%


2. САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

2025 онд хөрөнгө оруулалтын дүн 77.4 тэрбум төгрөгт хүрснээр хөрөнгө оруулалтын ашиг өмнөх оноос 0.8%-иар өсч, хөрөнгө оруулалтын өгөөж 14.8% гарсан байна.


Даатгалын үйл ажиллагааны ашиг өмнөх оноос 510%-иар өсөж, 4.3 тэрбумтөгрөгт хүрсэн нь Цэвэр ашиг 57%-иар өсөхөд нөлөөлсөн байна.

сая төгрөг	2024Q4	2025Q4	YoY
Даатгалын үйл ажиллагааны ашиг	717	4,371	510%
Хөрөнгө оруулалтын ашиг	8,272	8,340	0.8%
Цэвэр ашиг	8,332	13,086	57%
Өөрийн хөрөнгийн өгөөж	23.0%	30.1%	7.1%
Хөрөнгө оруулалтын өгөөж	18.0%	14.8%	-3.2%
Төлбөрийн чадварын түвшин	II	I	
Хохирлын харьцаа (сан орсон)	45.8%	51.5%	5.7%
Зардлын харьцаа	51.4%	37.5%	-13.9%
Нийлмэл харьцаа	97.2%	89.0%	-8.2%
Нийт хөрөнгө	122,607	137,778	12.4%
Хөрөнгө оруулалтын дүн	68,339	77,415	13.3%


Нийт хөрөнгө, тэрбум төгрөг





Хөрөнгө оруулалтын дүн, тэрбум төгрөг



Нийт хураамжийн орлого, тэрбум төгрөг




Цэвэр ашиг, тэрбум төгрөг



3. ХУВЬЦААНЫ ҮЗҮҮЛЭЛТ

2025 оны жилийн эцэст MNDL хувьцааны ханш 69.3 төгрөг байсан бөгөөд өмнөх оны жилийн эцэстэй харьцуулахад 1.8%-иар буурсан боловч нэгж хувьцаанд ногдох ашиг 20.96 төгрөг байна.

2025 онд нийт 22.0 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн байна.



ХАРААТ БУС АУДИТЫН ДҮГНЭЛТ



ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

МАНДАЛ ДААТГАЛ ХК-ийн хувьцаа эзэмшигчид

Аудиторын дүгнэлт

Бид Мандал Даатгал ХК (цаашид "Компани" гэх)–ийн 2025 оны 12 дугаар сарын 31–ний өдрөөрх Компанийн санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон үеийн жилийн дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр дээр нэрлэсэн санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31–ний өдрийн байдлаарх Компанийн санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөл ("НББОУСЗ")–өөс гаргасан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд ("СТОУС")–ын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт ("АОУС")–уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагуудыг энэхүү тайлангийн "Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага" хэсэгт харуулав. Бид Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан "Мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм"–ийн дагуу Компаниас хараат бус бөгөөд уг дүрэмд заасны дагуу өөрсдийн бусад ёс зүйн үүрэг хариуцлага бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэд хангалттай, зохистой үндэслэл болж чадна гэдэгт бид итгэлтэй байна.

Санхүүгийн тайлантай холбоотойгоор удирдлагын хүлээх хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг СТОУС–ын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах ба залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжийг бий болгоход шаардлагатай гэж удирдлагын тодорхойлсон дотоод хяналтуудад удирдлага хариуцлага хүлээнэ.

Компанийн удирдлага нь санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ Компанийн үйл ажиллагааг зогсоох эсвэл татан буулгахаар төлөвлөсөн эсвэл эдгээрээс өөр бодит сонголт байхгүйгээс бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа удирдлага нь тасралтгүй байх зарчмын дагуу Компанийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах чадварыг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэгтэй.

Компанийн удирдлага нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэгтэй.

Санхүүгийн тайлантай холбоотойгоор аудиторын хүлээх үүрэг

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу тайлагналуудаас санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаа олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм.

Зохистой баталгаажуулалт гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт боловч "АОУС"–ын дагуу хийгдсэн аудит нь оршин байгаа материаллаг буруу тайлагналуудыг байнга илрүүлнэ гэсэн баталгаа биш юм. Буруу тайлагналууд нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэдгээр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогдоно.

ХАРААТ БУС АУДИТЫН ДҮГНЭЛТ



ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Санхүүгийн тайлантай холбоотойгоор аудиторын хүлээх үүрэг (үргэлжлэл)

АОУС-ын дагуу хийх аудитын үед бид мэргэжлийн үнэлэмж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилладаг. Бид мөн:

- Залилан эсвэл алдааны улмаас үүсч болох санхүүгийн тайлангийн материаллаг буруу тайлагналуудын эрсдэлүүдийг таних, үнэлэх, тэдгээр эрсдэлд тохирох аудитын горимуудыг боловсруулах, гүйцэтгэх, өөрсдийн дүгнэлтэнд үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын нотолгоо олж авах. Залилан нь хуйвалдах, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу мэдэгдэл хийх, дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдтэй холбоотой байж болох тул залилангаас үүдэн гарсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүдэн гарсан буруу тайлагналыг ирүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг.
- Компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд дүгнэлт өгөх зорилгоор биш тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитад хамааралтай дотоод хяналтын талаар ойлголт олж авах.
- Хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь зохистой эсэх, удирдлагын зүгээс нягтлан бодох бүртгэлийн ойлроцоолсон тооцоолууд, тэдгээрт холбогдох тодруулгууд нь үндэслэлтэй эсэхийг үнэлэх.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын нотолгоонд үндэслэн Компанийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэж болох үйл явдал эсвэл нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг дүгнэх. Хэрэв материаллаг тодорхой бус байдал байна гэж дүгнэвэл, бид аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгыг хийж өгөх эсвэл ийм тодруулга хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэл олж авсан аудитын нотолгоонд үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөл байдал Компанийн тасралтгүй байх зарчмыг алдагдуулж болно.
- Санхүүгийн тайлангууд (үүнд тодруулгууд багтана)–ын ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлэх мөн санхүүгийн тайлангууд нь зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар холбогдох ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг үнэлэх.

Бид аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа, томоохон хэмжээний дутагдал болон аудитын явцад олж тогтоосон дотоод хяналтын томоохон доголдол зэргийг багтаасан асуудлуудыг Компанийн удирдлагад мэдэгддэг.

Бусад зүйл

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор бус, Монгол Улсын "Компанийн тухай хууль"–ийн 94 дүгээр зүйлд заасны дагуу компанийн хувьцаа эзэмшигчдийн захиалгаар аудитыг гүйцэтгэн Компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулан гаргалаа. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө харууллага хүлээхгүй болно

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК

Мэргэшсэн нягтлан бодогчид:



У.НАРАНДЭЛГЭР
Аудитор

Улаанбаатар хот, Монгол улс
Огноо: 2026 оны 2 дугаар сарын 9-ний өдөр

АШИГ, АЛДАГДАЛ БА БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН

МАНДАЛ ДААТГАЛ ХК

ХАВСРАЛТ 1

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН АШИГ, АЛДАГДАЛ БА БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ МАЯГТЫН ДАГУУХ ТОЛИЛУУЛГА

(Мянган төгрөгөөр)	2025	2024
Даатгалын хураамжийн нийт орлого	155,636,929	145,199,308
Даатгалын хураамжийн буцаалт	(4,263,935)	(3,707,893)
Давхар даатгалын хураамжийн зардал	(96,770,051)	(99,712,235)
Даатгалын хураамжийн цэвэр орлого	54,602,943	41,779,180
Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн өөрчлөлт	(3,242,780)	(12,367,501)
Хойшлогдсон давхар даатгалын хураамжийн өөрчлөлт	(984,761)	4,768,738
Орлогод тооцсон хураамж	50,375,402	34,180,417
Нийт нөхөн төлбөрийн зардал	(27,413,937)	(17,349,816)
Давхар даатгагчийн хариуцсан нөхөн төлбөр	1,269,304	1,322,113
Буруутай этгээдийн хариуцсан нөхөн төлбөр	199,832	359,494
Нөхөн төлбөрийн цэвэр зардал	(25,944,801)	(15,668,209)
Нөхөн төлбөрийн нөөц сангийн өөрчлөлт	(4,922,171)	(1,867,718)
Нөхөн төлбөрийн нөөц сангийн давхар даатгагчид ногдох	3,142,373	51,133
Учирч болзошгүй хохирлын нөөц сангийн өөрчлөлт	644,571	(312,169)
Зардалд тооцсон нөхөн төлбөр	(27,080,028)	(17,796,963)
Даатгалын гэрээний зардал	(5,492,196)	(4,847,970)
Давхар даатгалын шимтгэлийн орлого	169,450	1,034,179
Хөрөнгө оруулалтын олз, гарз	9,516,422	8,900,725
Даатгалын үйл ажиллагааны ашиг	27,489,050	21,470,388
Бусад орлого	102,190	358,624
Ерөнхий ба удирдлагын зардал	(12,397,043)	(10,809,220)
Борлуулалт, маркетингийн зардал	(612,443)	(600,806)
Санхүүгийн зардал	(83,677)	(95,647)
Бусад зардал	(314,270)	(1,213,485)
Гадаад валютын ханшийн зөрүүний олз / (гарз)	61,662	87,114
Биет болон биет бус хөрөнгө данснаас хассаны олз / (гарз)	273,730	(18,488)
Бусад ашиг / (алдагдал)	(12,969,851)	(12,291,908)
Татвар төлөхийн өмнөх ашиг	14,519,199	9,178,480
Орлогын албан татварын зардал	(1,432,700)	(846,696)
Тайлант жилийн цэвэр ашиг	13,086,499	8,331,784
Бусад дэлгэрэнгүй орлого	748,557	142,911
Нийт дэлгэрэнгүй орлого	13,835,056	8,474,695

САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

МАНДАЛ ДААТГАЛ ХК

ХАВСРАЛТ 2

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨРХ САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ МАЯГТЫН ДАГУУХ ТОЛИЛУУЛГА

(Мянган төгрөгөөр)	2025.12.31	2024.12.31
ХӨРӨНГӨ		
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	737,901	1,031,407
Ашиглах эрхтэй хөрөнгө	338,058	399,957
Биет бус хөрөнгө	37,007	105,226
	<u>1,112,966</u>	<u>1,536,590</u>
Эргэлтийн хөрөнгө		
Бараа материал	23,476	23,737
Урьдчилж төлсөн төлбөр, тооцоо ба бусад	839,560	353,058
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө	2,776,701	2,776,701
Авлага	6,398,215	3,832,870
Давхар даатгагчид ногдох даатгалын нөөц	43,849,740	41,692,128
Даатгалын орлогын шимтгэлийн хойшлогдсон зардал	2,599,772	2,790,735
Богино хугацаат хөрөнгө оруулалт	76,959,366	49,088,463
Хугацаат хадгаламж	455,285	19,250,288
Бусад санхүүгийн хөрөнгө	576,555	532,508
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	2,186,590	730,418
	<u>136,665,260</u>	<u>121,070,906</u>
НИЙТ ХӨРӨНГӨ	<u>137,778,226</u>	<u>122,607,496</u>
ЭЗДИЙН ӨМЧ БА ӨР ТӨЛБӨР		
Эздийн өмч		
Хувьцаат капитал	6,243,016	6,243,016
Нэмж төлөгдсөн капитал	4,441,896	4,441,896
Халаасны хувьцаа	(2,282,564)	-
Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний нэмэгдлийн нөөц сан	972,490	223,933
Хуримтлагдсан ашиг	40,241,504	32,211,848
	<u>49,616,342</u>	<u>43,120,693</u>
Богино хугацаат өр төлбөр		
Даатгалын нөөц сангууд	80,553,384	73,033,004
Давхар даатгалын өр төлбөр	4,373,089	3,782,392
Дансны болон бусад өр төлбөр	1,906,439	2,118,857
Орлогын албан татварын өр төлбөр	926,908	106,015
Түрээсийн өр төлбөр	354,986	290,494
	<u>88,114,806</u>	<u>79,330,762</u>
Урт хугацаат өр төлбөр		
Хойшлогдсон татварын өр төлбөр	47,078	156,041
	<u>47,078</u>	<u>156,041</u>
Нийт өр төлбөр	<u>88,161,884</u>	<u>79,486,803</u>
НИЙТ ЭЗДИЙН ӨМЧ БА ӨР ТӨЛБӨР	<u>137,778,226</u>	<u>122,607,496</u>

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

МАНДАЛ ДААТГАЛ ХК

ХАВСРАЛТ 3

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨРХ ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ МАЯГТЫН ДАГУУХ ТОЛИЛУУЛГА

(Мянган төгрөг)	Хувьцаат капитал	Нэмж төлөгдсөн капитал	Халаасны хувьцаа	Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний нэмэгдлийн нөөц сан	Хуримтлагдсан ашиг	Нийт
2024 оны 1 сарын 1	6,243,016	4,441,896	-	81,022	23,880,064	34,645,998
Нийт дэлгэрэнгүй орлого	-	-	-	142,911	8,331,784	8,474,695
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-	-
2024 оны 12 сарын 31	6,243,016	4,441,896	-	223,933	32,211,848	43,120,693
Нийт дэлгэрэнгүй орлого	-	-	-	748,557	13,086,499	13,835,056
Халаасласан энгийн хувьцаа	-	-	(2,282,564)	-	-	(2,282,564)
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	(5,056,846)	(5,056,846)
2025 оны 12 сарын 31	6,243,016	4,441,896	(2,282,564)	972,490	40,241,504	49,616,342



МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

МАНДАЛ ДААТГАЛ ХК

ХАВСРАЛТ 4

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨРХ МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ МАЯГТЫН ДАГУУХ ТОЛИЛУУЛГА

(Мянган төгрөгөөр)	2025	2024
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Даатгалын хураамжийн орлого	147,941,691	141,470,244
Давхар даатгалын нөхөн төлбөр	665,160	44,373
Бусад мөнгөн орлого	923,452	1,340,439
Мөнгөн орлогын дүн	149,530,303	142,855,056
Ажиллагчдад төлсөн	(6,181,057)	(5,222,946)
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	(1,835,000)	(1,840,000)
Бараа материал худалдан авахад төлсөн	(24,994)	(12,789)
Ашиглалтын зардалд төлсөн	(120,085)	(107,981)
Давхар даатгагчид төлсөн давхар даатгалын хураамж	(94,739,375)	(84,913,112)
Нөхөн төлбөрт төлсөн	(27,223,051)	(16,819,384)
Үүнээс: Сайн дурын даатгалын	(26,543,330)	(15,443,542)
Албан журмын даатгалын	(679,721)	(1,375,842)
Даатгалын төлөөлөгчийн шимтгэл	(1,486,001)	(2,180,047)
Даатгалын зуучлагчид төлсөн төлбөр	(3,422,182)	(2,391,244)
Даатгалын хохирол үнэлэгчид төлсөн төлбөр	(12,800)	(98)
Төлсөн хүү	(374,886)	-
